



Journal of Security and Defense Studies

Journal homepage:
https://mids.gov.mn/category/ayulgui_baidal-2/

ISSN: 2220-9115, E-ISSN: 2708-1230



Research Article

DOI: <https://doi.org/10.65816/jsds.2026.02.015>

Comparative Study of Military Wind Band Musician Training Practices in Mongolia and Selected Foreign Countries

Gombojav Batdorj¹, Tsedev Purev²

¹Senior Lecturer and Doctoral Candidate, Department of Professional Education, Mongolian National Defense University, Ulaanbaatar, Mongolia, E-mail address: batdorj445@gmail.com

²Ph.D., Professor, Mongolian National Defense University, Ulaanbaatar, Mongolia
E-mail address: tsedev5112@gmail.com

Received: 29 May 2026

Revised: 23 June 2026

Accepted: 26 June 2026

Published online: 28 July 2026



ABSTRACT

Military wind music is an integral component of state and military ceremonial events, and it plays an important role in fostering patriotism, military discipline, and national pride, as well as in promoting a country's cultural values at the international level. It is a distinct field of art that holds significant importance in this regard.

In Mongolia, the beginning of military wind musician training is considered to have been established in 1914 with the formation of the wind music unit of the Bogd Khan's Imperial Guard. Subsequently, the tradition of training military wind musicians has continuously developed based on apprenticeship methods since the period of the Mongolian People's Revolutionary Army.

Although the training of military wind musicians in Mongolia has developed to a certain extent, there remains a need to deepen comparative research based on international trends and foreign experience in order to define future development directions. Therefore, this article examines the current situation of military wind musician training in Mongolia. It also conducts a comparative study with the training practices of selected foreign countries. The study aims to identify possible directions and approaches for future development. Furthermore, it indicates that improving the quality of basic professional training, introducing international experience, and expanding cooperation are key priorities for the future development of military wind musician training.

Keywords. Military music, Training, International Experience, Skills, Comparison

Монгол Улс болон гадны зарим улс орнуудад цэргийн үлээвэр хөгжимчин бэлтгэж буй туршлага, харьцуулсан судалгаа

Гомбожав Батдорж¹ Пүрэв Цэдэв²

¹Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургуулийн Мэргэжлийн боловсролын тэнхимийн ахлах багш,
докторант, batdorj445@gmail.com

²Үндэсний Батлан Хамгаалахын Их Сургууль, доктор (Ph.D), профессор, tsdev5112@gmail.com

ХУРААНГУЙ

Цэргийн үлээвэр хөгжим нь төр, цэргийн ёслол хүндэтгэлийн арга хэмжээний салиггүй бүрэлдэхүүн хэсэг төдийгүй эх оронч үзэл, цэргийн сахилга бат, үндэсний бахархлыг төлөвшүүлэх, улс орны соёлын үнэт зүйлсийг олон улсын түвшинд сурталчлан таниулах онцгой ач холбогдолтой урлагийн салбарын нэг бүрэлдэхүүн юм.

Монгол Улсад цэргийн үлээвэр хөгжимчин бэлтгэх үйл ажиллагааны эхлэл нь 1914 онд Богд хааны торгон цэргийн үлээвэр хөгжмийн бүрэлдэхүүн байгуулагдсанаар тавигдсан гэж үздэг. Улмаар цэргийн үлээвэр хөгжимчнийг бэлтгэх уламжлал нь Монгол Ардын Журамт Цэргийн үеэс эхлэн шавь сургалтын арга барилд тулгуурлан тасралтгүй хөгжсөөр иржээ. Монгол Улсад цэргийн үлээвэр хөгжимчин бэлтгэх үйл ажиллагаа тодорхой хэмжээнд хөгжсөн хэдий ч олон улсын чиг хандлага, гадаадын туршилагд тулгуурласан харьцуулсан судалгааг гүнзгийрүүлэх замаар цаашид хөгжлийн чиглэлийг тодорхойлох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Иймээс энэхүү өгүүлэлд Монгол Улсад цэргийн үлээвэр хөгжимчин бэлтгэж буй өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлов. Мөн гадаадын зарим улсын сургалт, бэлтгэлийн туршилагатай харьцуулан судалсан болно. Цаашид хөгжлийн боломжит чиглэл, арга замыг тодорхойлохыг зорьсон. Мөн цэргийн үлээвэр хөгжимчин бэлтгэх үйл ажиллагаанд мэргэжлийн суурь бэлтгэлийн чанарыг дээшлүүлэх, олон улсын туршилагыг нэвтрүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх нь цаашид хөгжлийн тэргүүлэх чиглэл болох нь харагдаж байна.

Түлхүүр үгс: Цэргийн хөгжим, сургалт, гадаадын улсын туршилага, ур чадвар, харьцуулалт.

Удиртгал

Монгол Улсад цэргийн хөгжмийн сургалт Богд хааны торгон цэргийн үлээвэр хөгжмөөс эхлэлтэй бөгөөд дараа нь Монгол ардын журамт цэргийн хөгжмийн бүрэлдэхүүнээр дамжин шавь сургалтын хэлбэрээр хөгжсөн байна. Тухайн үед мэргэжлийн багш, онолын багш, удирдаач бүрэн бүрдээгүй байсан бөгөөд “Оросын иргэн Анатолий Алексеевич Кольцовыг найрал хөгжмийн сургагч багшаар урьж Европын сонгодог үлээвэр хөгжим, ноотны тэмдэглэгээ уншлагыг анх заалгаж байжээ” (Г.Ганбат 2019). Мөн энэ үеэс эхлэн ахмад хөгжимчид залуу хөгжимчдийг дагалдуулан сургах зарчим түгэн дэлгэрч, сургалтын үйл ажиллагаа улам өргөжин хөгжсөн байна.

Цэргийн хөгжим нь цэрэг, албан хаагчдын сахилга бат, гоо зүйн хүмүүжилд төлөвшүүлэхээс гадна төр, цэргийн ёслолын сүр жавхааг илэрхийлэх чухал үүрэгтэй. Мөн олон улсын дипломат харилцааг өргөжүүлэх, бэхжүүлэх үйл хэрэгт цаг агаар, газар орны эрс тэс нөхцөлөөс үл хамааран мэргэжлийн өндөр түвшинд оролцож, улс орны нэр хүндийг дэлхий дахинд сурталчлан таниулах соёлын элчийн үүргийг гүйцэтгэдгээрээ онцлог салбар юм.

Харин Монгол Улсад сургалтын тогтолцоо хөгжлийн шатандаа явж байгаа бөгөөд хүний нөөц, гадаад хамтын ажиллагааг цаашид өргөжүүлэх шаардлага

байна.

Монгол Улсад цэргийн үлээвэр хөгжимчин бэлтгэх үйл ажиллагаа нь түүхэн уламжлалтай хэдий ч орчин үеийн боловсролын хөгжлийн чиг хандлага, хөдөлмөрийн зах зээлийн шаардлагатай уялдуулан шинэчлэн авч үзэх судалгааны хэрэгцээ улам бүр нэмэгдэж байна. Сүүлийн жилүүдэд энэ чиглэлээр тодорхой ахиц дэвшил гарч байгаа боловч олон улсын туршлага, тэр дундаа гадаадын улс орнуудын цэргийн хөгжимчин бэлтгэх сургалтын тогтолцоо, арга зүйтэй харьцуулсан судалгаа хангалтгүй хэвээр байна. Иймээс энэхүү асуудлыг судлах нь онолын болон практикийн ач холбогдолтой юм.

Энэхүү судалгааны өгүүллийн зорилго нь

Монгол улс болон гадны зарим улсад цэргийн үлээвэр хөгжимчин бэлтгэх үйл ажиллагааг харьцуулан судалж, манай оронд хэрэгжиж буй сургалтын өнөөгийн байдлыг тодорхойлон, цаашдын хөгжлийн боломжит чиглэлийг тодорхойлоход чиглэгдэнэ.

Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэв. Үүнд:

1. Монгол Улсын цэргийн үлээвэр хөгжмийн сургалтын түүхэн хөгжлийг шинжлэх;
2. Гадаадын зарим улсад цэргийн үлээвэр хөгжимчин бэлтгэх туршлагыг харьцуулан судлах;
3. Харьцуулсан судалгааны үндсэн дээр Монгол Улсад хэрэгжүүлэх боломжтой чиглэлийг тодорхойлоход оршино.

Судалгааны арга зүй: Судалгаанд түүхэн харьцуулалтын арга, баримт бичгийн задлан шинжилгээний арга, мөн албан ёсны эх сурвалжид тулгуурласан харьцуулсан судалгааны аргыг ашиглав. Мөн холбогдох хууль, дүрэм, сургалтын баримт материалтай танилцсан болно.

Судалгааны үр дүн:

Их Британи, Америкийн Нэгдсэн Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Япон Улс, Оросын Холбооны Улсад цэргийн хөгжимчин бэлтгэх үйл ажиллагаа нь суурь хөгжмийн ур чадварын үнэлгээнд тулгуурласан сонгон шалгаруулалт, онол-практик хосолсон сургалт, мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх арга хэлбэрээр хэрэгжиж байна. Харин Монгол Улсад цэргийн үлээвэр хөгжимчин бэлтгэх үйл ажиллагаа тодорхой ахицтай хөгжиж буй хэдий ч хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, сургалт-бэлтгэлийн арга хэлбэрийг боловсронгуй болгох шаардлага байгааг судалгааны үр дүн харуулж байна.

Үндсэн хэсэг

Монгол Улсын цэргийн хөгжмийн сургалт нь тухайн цаг үеийн нийгэм, улс төрийн тогтолцоо, Зэвсэгт хүчний хөгжлийн хэрэгцээ, төрийн болон цэргийн ёслолын үйл ажиллагааны шаардлагатай уялдан хөгжиж ирсэн. Энэхүү хөгжлийн явцад сургалтын зохион байгуулалт, агуулга, арга хэлбэр нь тасралтгүй өөрчлөгдөн боловсронгуй болсон байна. Иймээс энэхүү өгүүлэлд Монгол Улсын цэргийн хөгжмийн сургалтын түүхэн хөгжил, зохион байгуулалт, агуулгын өөрчлөлтийг нийгэм, улс төрийн тогтолцооны хувьсалтай уялдуулан шинжилж, хөгжлийн

онцлог, сургалтын хэлбэрээр нь таван үндсэн үе шат болгон ангилан авч үзэв. Үүнд:

1. Богд хааны болон Монгол ардын журамт цэргийн үлээвэр хөгжмийн сургалтын үе (1914-1931)

- Богд хааны торгон цэргийн сургалт (1914-1921) ба Монгол ардын журамт цэргийн сургалт (1922-1931)-ыг нэгтгэж, анхны сургалт, бүрээчийн анги байгуулагдсан үе.

2. Цэргийн хөгжмийн албаны сургалт, бэлтгэлийн үе (1932-1949)

- Найрал хөгжмийн сургалт удирдамжтай болж, ноотны сурах бичиг хэвлэгдсэн үе.

3. Төрийн ба цэргийн хөгжмийн тогтолцоо бүрэлдсэн үе (1950-1990)

- Социалист бүтээн байгуулалтын үе, төрийн ёслол, цэргийн ёслолын арга хэмжээнд өндөр ур чадвартай найрал хөгжмийн бүрэлдэхүүнтэй болсон.

4. Ардчилсан хувьсгалаас хойших мэргэжлийн сургалтын шинэчлэлийн эхэн үе (1991-2005)

- Мэргэжлийн цэргийн үлээвэр хөгжимчдийг бэлтгэх байнгын дамжаа, сургууль, коллеж байгуулагдан, сургалтын тогтолцоо боловсронгуй болсон үе.

5. Цэргийн хөгжмийн сургалтын орчин үеийн хөгжлийн үе (2006-2026)

- Орчин үеийн олон улсын чиг хандлага, дэвшилтэт арга зүй, технологийг нэвтрүүлж, сургалтын чанар, мэргэжлийн ур чадварын түвшинг нэмэгдүүлсэн үе.

Дээрх үечлэлээс үзэхэд “1914 онд Богд хааны ордны торгон цэргийн үлээвэр хөгжмийн бүрэлдэхүүн байгуулагдсан” ([Цэргийн хөгжмийн коллежийн түүхэн замнал 2021](#)) нь Монгол Улсад орчин цагийн сонгодог хөгжмийн үүсэл, хөгжлийн эхлэлийг тавьж, дэлхийн хөгжмийн боловсролоос суралцах анхны суурь нөхцөлийг бүрдүүлсэн. Улмаар анхан шатны сургалтаас эхлэн байнгын дамжаа, сургууль, коллежийн шаталсан тогтолцоо бүрэлдэн, сургалтын агуулга, хөтөлбөр тасралтгүй боловсронгуй болсон нь цэргийн үлээвэр хөгжмийн салбарын өнөөгийн хөгжлийн түвшинд хүрэхэд чухал нөлөө үзүүлжээ.

Монгол Улсад цэргийн үлээвэр хөгжимчнийг мэргэжлийн түвшинд бэлтгэдэг цорын ганц сургалтын байгууллага нь Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн харьяа Цэргийн хөгжмийн политехник коллеж юм. Тус сургуулийн сургалтын зорилго нь цэргийн сахилга бат, ёс зүйтэй, жагсаалын нөхцөлд хөгжмийн зэмсгийг мэргэжлийн өндөр түвшинд эзэмшин тоглох чадвартай, төрийн болон цэргийн ёслолын ажиллагаанд үүрэг гүйцэтгэх мэдлэг, ур чадвар, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлтэй хөгжимчнийг төлөвшүүлэхэд чиглэдэг. Энэхүү зорилгыг хэрэгжүүлэхийн тулд сургалтыг ганцаарчилсан, хөгжмийн төрлөөр хэсэгчилсэн, цөөхүүл найрал хөгжмийн, бага болон их найрал хөгжмийн гэсэн үндсэн хэлбэрээр онол, практикийг уялдуулан зохион байгуулдаг.

Монгол Улсын ЗХЖШ-ын Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн хамт олон болон ҮБХИС-ийн Цэргийн хөгжмийн политехник коллежийн багш, суралцагчид 2000 оноос хойш олон улсын цэргийн хөгжмийн наадамд тогтмол оролцож ирсэн нь сургалтын чанар, үр нөлөөг бодитой үнэлэх чухал үзүүлэлт болж байна.

Энэхүү оролцоо нь хөгжимчдийн мэргэжлийн ур чадварыг олон улсын түвшний гүйцэтгэлтэй харьцуулах, сургалтын үр өгөөжийг практик үйл ажиллагаагаар баталгаажуулах боломжийг бүрдүүлж байна.

Тодруулбал, Монгол Улсын цэргийн хөгжимчид Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Их Британи, Бүгд Найрамдах Турк Улс, мөн БНХАУ-ын Хонг Конгийн Тусгай захиргааны бүсэд зохион байгуулагдсан олон улсын цэргийн хөгжмийн наадам, фестиваль, ёслолын арга хэмжээнд тогтмол оролцож ирсэн байна. Эдгээр арга хэмжээнд үзүүлсэн тоглолт, ёслолын болон жагсаалын гүйцэтгэл нь зохион байгуулагч байгууллагын шаардлагад нийцэж, оролцогч талуудын зүгээс эерэг үнэлгээ авч ирсэн нь Монгол Улсын цэргийн үлээвэр найрал хөгжмийн хамт олны мэргэжлийн бэлтгэл, гүйцэтгэлийн чанар олон улсын түвшинд өрсөлдөхүйц байгааг илтгэж байна.

Түүнчлэн олон нийтэд нээлттэй дүрс бичлэгийн баримтаас найрал хөгжмийн дуугаралт, гүйцэтгэлийн чанар, хөгжим болон жагсаалын хөдөлгөөний уялдаа нь олон улсын цэргийн хөгжмийн наадмын шаардлагад нийцэж буйг ажиглах боломжтой. Иймээс олон улсын наадам, фестивалд тогтмол оролцож буй бодит туршлага нь Монгол Улсад хэрэгжиж буй цэргийн үлээвэр хөгжимчин бэлтгэх сургалтын хөтөлбөр, сургалтын арга зүй, сургалтын зохион байгуулалтын үр нөлөө, төгсөгчдийн мэргэжлийн чадамжийг практик үйл ажиллагааны үр дүнгээр үнэлэх чухал үндэслэл болж байна.

Монгол улсад цэргийн үлээвэр хөгжимчний сургалтын өнөөгийн чиг хандлага хэр оновчтой бэлтгэж байгааг гадаадын зарим улсын цэргийн хөгжимчдийг бэлтгэх сургалтын өнөөгийн туршлагатай харьцуулан үзсэнээр танин мэдэж болно. Өөрөөр хэлбэл, бид гадаадын улс орнуудын цэргийн үлээвэр хөгжимчин бэлтгэх сургалтын тогтолцоог судалж, ололт, амжилтаас сургамж авч сургалтын үйл ажиллагаандаа тусгах нь зайлшгүй хэрэгцээ болж байна.

Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улсад цэргийн хөгжмийн сургалтыг явуулж ирсэн туршлага


Цэргийн хөгжмийн үйл ажиллагаа нь маш нарийн зохион байгуулалттай, ихээхэн цар хүрээтэй байдаг. Үүний тод жишээ бол British Army буюу Их Британийн арми юм. “Их Британийн армид томоохон хөгжмийн хамтлагууд үүрэг гүйцэтгэдэг бөгөөд тус хөгжмийн хамтлагууд нь арми дахь урлаг соёл, ёслол, олон улсын арга хэмжээнд оролцдог” ([Royal Corps of Army Music. British Army Official 2026](#)) гэжээ. Эндээс үзвэл Их Британийн армийн хөгжмийн хамтлагууд нь батлагдсан бүтэц, мэргэжлийн хөгжимчдийн бүрэлдэхүүнээрээ арми дахь урлаг, ёслол хүндэтгэл болон олон улсын арга хэмжээнд тасралтгүй оролцож, хөгжмийн албаны үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулж байгааг харуулж байна. Хөгжмийн сургалтын талаар албан ёсны цахим хуудсандаа “Симфони болон үлээвэр найрал хөгжим, гитар зэрэг бүх төрлийн хөгжмийн зэмсэгт тохируулан явуулдаг ба сонгодог, жазз, свинг, поп, гэх мэт (жанр) төрлүүдээр хичээллэдэг” ([the-royal-corps-of-army-music 2026](#)) гэж бичжээ. Эндээс үзвэл хөгжмийн сургалт нь, мэргэжлийн өндөр түвшний сургалттай бөгөөд сурагчдыг олон төрлийн хөгжмийн зэмсэг, төрөл (жанр)-аар мэргэжлийн ур чадвартай хөгжмийн мэргэжилтэн болгон

бэлтгэдэг байна.

Анхан, дунд, ахисан шатны гуулин болон утсан, цохивор зэрэг хөгжмийн төрөл мэргэжлүүдээр тус бүрд зориулсан сургалтууд явагддаг байна.

Их Британийн армийн ахлагч нарын цолны шатлалыг ахлагчийн албан тушаалын зэрэглэлтэй уялдуулан авч үзвэл, цэргийн хөгжмийн ахлагч нар дараах албан тушаалуудыг хаших боломжтой гэж үзэж болно. Үүнд:

1. Lance Corporal,
2. Corporal, Sergeant,
3. Sergeant,
4. Sergeant major ([The Royal Corps of Army Music. 2026](#))



Зураг 1. Их Британийн армийн ахлагч нарын цолны шатлал

Lance Corporal (Дэд түрүүчээс нэг шат доогуур түвшин) Анхан шатны удирдах түвшний хөгжимчин бөгөөд найрал хөгжмийн бүрэлдэхүүнд гүйцэтгэгчийн үүрэг гүйцэтгэнэ. Дадлага, сургалтын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож, бага бүрэлдэхүүнийг зохион байгуулах, ахлах хөгжимчдийг дэмжих чиг үүрэгтэй;

Corporal (Дэд түрүүч) Бага болон дунд түвшний удирдах үүрэгтэй хөгжимчин бөгөөд хэсэг бүлгийн сургалт, дадлагыг хариуцан зохион байгуулна. Найрал хөгжмийн дэг журам, гүйцэтгэлийн чанарыг хангах, залуу хөгжимчдийг сургах, чиглүүлэх үүрэгтэй;

Sergeant /Band/ (Ахлах түрүүч) Ахлах түвшний хөгжимчин бөгөөд найрал хөгжмийн өдөр тутмын үйл ажиллагаа, сургалт, тоглолтын зохион байгуулалтад голлох үүрэг гүйцэтгэнэ. Хөгжимчдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, сахилга бат, зохион байгуулалтыг хангах, удирдлагын шийдвэрийг хэрэгжүүлэх үүрэгтэй;

Sergeant Major /Band/ (Ахлах ахлагч) Цэргийн хөгжмийн нэгжийн хамгийн ахлах түвшний удирдах албан тушаалтан бөгөөд нийт бүрэлдэхүүний мэргэжлийн түвшин, сахилга бат, ёс зүйг хариуцна. Найрал хөгжмийн бодлого, стратеги, төлөвлөлтөд оролцож, удирдлага болон хөгжимчдийн хоорондын уялдаа холбоог хангах гол үүрэгтэй байдаг байна.

АНУ-д Тэнгисийн цэргийн академийн цэргийн хөгжмийн сургалтыг явуулж буй туршлага

АНУ-ын Тэнгисийн цэргийн академи. Тус Академийн бүтцэд харьяалагдах Хөгжмийн хэлтэс (Music Department) нь суурь мэдлэг ур чадвартай хөгжимчдийг тэнгисийн цэргийн албанд тусгай шалгуураар элсүүлэхийн зэрэгцээ жагсаалын арга хэмжээ, ёслол хүндэтгэлийн үндсэн үйл ажиллагаануудад оролцох зорилготой байдаг байна.

Сонгогдсон суралцагчдыг 6–12 сарын хугацаатай тусгай сургалтын

хөтөлбөрөөр бэлтгэж, шалгуур үнэлгээнд тэнцсэн тохиолдолд Тэнгисийн цэргийн академийн хөгжмийн бүрэлдэхүүнд албан ёсоор элсүүлэн цэргийн албанд ажиллуулдаг байна.

АНУ-д мэргэжлийн ахлагч нарыг бэлтгэх сургалтын талаар доктор Ц.Оюунчимэг “Ахлагч нарыг бэлтгэх бүх шатны дамжаанууд албан тушаал ахихад зайлшгүй шаардлагатай сургалтын хэлбэрүүд бөгөөд цэргийн албаны 20 жилийн туршид эдгээр курсийг шат дараалан дүүргэдэг байна” ([Ц.Оюунчимэг 2023](#)) гэжээ. Эндээс үзвэл шаталсан сургалтын тогтолцоо боловсронгуй болсон хэмээн үзэж болохоор байна.

Хөгжимчин цэргийн албан хаагчдаас албан ёсоор дунд боловсролын гэрчилгээ (High School diploma) эсвэл түүнтэй дүйцэх GED шаардагддаг бөгөөд хөгжмийн мэргэжлийн диплом заавал байх албагүй. Гэсэн хэдий ч бодит “Сонгон шалгаруулалтын явцад хөгжмийн сургууль, коллеж, эсвэл консерваторид суралцсан байдал нь өрсөлдөх чадварыг мэдэгдэхүйц нэмэгдүүлдэг” ([U.S. Army Band Career. 2025](#)) гэжээ. Эндээс үзвэл сонгон шалгаруулалт нь өндөр түвшний тоглолтын шалгалтад (audition-буюу сонсгол, ур чадвар) тулгуурладаг бөгөөд хөгжимчний техникийн чадвар, ноот унших чадвар (sight-reading), зэргийг нарийвчлан үнэлдэг байна.

Бүгд Найрамдах Турк Улсад цэргийн хөгжмийн сургалтыг явуулж буй туршлага

Турк Улсын Зэвсэгт хүчин дотоодын болон гадаадын цэргийн хөгжмийн хамтлагуудад үүрэг гүйцэтгэх цэргийн хөгжмийн мэргэжилтэн бэлтгэх тогтолцоотой.

Тус сургууль нь “Академийн сургалтыг Боловсролын дээд зөвлөл ба Европын Холбооны боловсролын стандартад нийцүүлэн багш нар, мэргэжлийн болон академийн түвшний боловсрол эзэмшсэн офицерууд болон энгийн багш нар хичээл заадаг бөгөөд хувь ганцаарчилсан болон, цөөхүүл хичээлүүд 1-5, бүлгийн хичээлүүд 25-30 хүний орчин үеийн суралцах өрөө болон анги танхимд явагддаг” ([Bando Astsubay Meslek Yüksekokulu Milli Savunma Üniversitesi 2025](#)) гэжээ.

Хөгжимчин бэлтгэх сургалтын хөтөлбөр нь “Хоёр жилийн боловсрол олгодог сургууль бөгөөд дотоод, гадаадын хэмжээнд чухалд тооцогдох сургуулиудын нэг юм. Тус сургуулийн Сургалтад ‘Үлээвэр болон цохивор хөгжим’ мөн ‘Хөгжмийн хэрэгслийн засвар үйлчилгээ’ гэсэн хоёр үндсэн хэрэгждэг” ([Bando Astsubay Meslek Yüksekokulu Milli Savunma Üniversitesi 2025](#)) гэжээ.

Эндээс үзвэл сургалтын хөтөлбөр нь хөгжмийн онол, соноршуулга, үлээвэр болон цохивор хөгжмийн төрлүүдээр, ансамбль, марш хөгжим, техникийн дасгал зэрэг академик болон практик чадварыг хослуулан хэрэгжүүлэхээр зохион байгуулагддаг болох нь харагдаж байна.

Япон Улсад цэргийн хөгжмийн сургалтыг явуулж буй туршлага

Япон Улсад цэргийн хөгжмийн мэргэжилтнүүдийг бэлтгэх сургалтын тогтолцоо нь өөрийгөө хамгаалах хүчний хөгжмийн хамтлагуудтай уялдан зохион байгуулагддаг бөгөөд суралцагчид хөгжмийн ур чадвар, найрал хөгжмийн үйл ажиллагаа, марш хөгжим зэрэг мэргэжлийн дадлагыг төлөвлөгөөт шаталсан хичээл, практик сургалтын дагуу эзэмшдэг.

Энэхүү тогтолцоо нь цэргийн хөгжмийн салбарт сайн дурын үндсэн дээр элсэх нөхцөлийг бүрдүүлдэг байна. Дунд болон ахлах сургуулийн хөгжмийн хамтлагийн сургалт нь хөгжмийн онол, ур чадварын бэлтгэл, сахилга, зохион байгуулалт, тогтмол дадлагад тулгуурладаг бөгөөд эдгээр нь цэргийн хөгжмийн бэлтгэлийн дүрэм, арга зүйтэй төстэй шинжийг агуулдаг байна.

Өөрөөр хэлбэл; Япон Улсад цэргийн хөгжимчдийг бэлтгэх үйл явц нь зөвхөн цэргийн мэргэжлийн сургалтын байгууллагад төвлөрөхөөс гадна ерөнхий боловсролын сургуулиуд дахь хөгжмийн сургалт, хамтлагийн тогтолцоотой нягт уялдсан, тасралтгүй хөгжих загвартайгаар хэрэгжиж байна. Үүнийг судлаачийн зүгээс цэргийн хөгжимчин бэлтгэх сургалтын тогтолцоог өргөн суурьтай, тогтвортой хүний нөөцөөр хангах оновчтой жишээ гэж үзэх үндэслэлтэй байна.

Оросын Холбооны Улсад цэргийн хөгжмийн сургалтыг явуулж буй туршлага

Оросын Холбооны Улсын /ОХУ/-ын цэргийн хөгжимчдийг бэлтгэдэг сургууль бол Валерий Михайлович Халиловын нэрэмжит “Москвагийн цэргийн хөгжмийн сургууль” (Московское Военно-Музыкальное училище) юм.

Тус сургуульд ерөнхий боловсролын 9 дүгээр анги төгссөн, хөгжмийн суурь мэдлэгтэй сурагчдыг сонгон шалгаруулалтаар элсүүлдэг бөгөөд сургалт нь 4 жилийн хугацаатай, дотуур байранд байрлуулж сургалт явагддаг. Эхний 2 жилд ерөнхий боловсролын хичээл, сүүлийн 2 жилд хөгжмийн мэргэжлийн сургалтыг гүнзгийрүүлэн боловсрол эзэмшүүлдэг. Төгсөлтийн шалгалт нь 1.Хөгжимдөх ур чадвар 2.Цөөхүүл хөгжим 3.Хөгжим заах арга зүй 4.биеийн тамир хичээлүүдээр улсын шалгалт өгдөг байна. Төгсөгчдөд цэргийн цол олгодоггүй. Тодруулбал; Дээрх хугацаанд суралцаж төгсөөд Александр Невскийн нэрэмжит цэргийн хөгжмийн дээд сургуульд хөгжмийн удирдаач болон бусад хөгжмийн консерваторт дэвшин суралцдаг байна.

ОХУ-ын В.М.Халиловын нэрэмжит Москвагийн Цэргийн хөгжмийн сургуулийн төгсөгчид нь армын хөгжмийн салбарт хөгжимчин ахлагч цолтой ажиллах боломж нээлттэй байдаг. ОХУ-ын армид ахлагчийн бүрэлдэхүүнд ажиллахад 5 -аас доошгүй жилийн хугацаанд ажиллах гэрээ байгуулдаг байна. Энэ талаар доктор Ц.Оюунчимэг судалгааны бүтээлдээ “Сургуулийн жилийн эцэст сонсогч нар улсын шалгалтаа амжилттай өгсөн бол анги салбарууд руу мэргэжлийнх нь дагуу хуваарилж, 5-аас доошгүй жил ажиллах гэрээ байгуулна” (Ц.Оюунчимэг 2023) гэжээ. Эндээс үзэхэд цэргийн сургууль, хугацаат цэргийн албанаас ахлагчийн албанд тэнцэн томилогдсон тохиолдолд тодорхой хугацаа зааж гэрээ байгуулах нь тэдний албандаа үнэнч, тогтвор суурьшилтай ажиллахад эрх зүйн зохицуулалт болдог байна. Судалгаанд хамрагдсан улс орнуудын цэргийн хөгжмийн сургалтын тогтолцоо, онцлогийн харьцуулсан шинжилгээг хүснэгт 1-д харуулав.

Хүснэгт 1. Цэргийн хөгжмийн сургалтын олон улсын туршилагын харьцуулалт

Турк	АНУ	Их Британи	Улс
Цэргийн ахлагчийн мэргэжлийн ур чадвар болон хөгжмийн ур чадварыг хослуулах	Бүх зэвсэгт хүчинд цэргийн хөгжмийн мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх, үндсэн болон мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх	Цэргийн хөгжмийн ёслол, стандартын түвшнийг хадгалах; мэргэжлийн хөгжимчид бэлтгэх (Төр, Цэргийн ёслол)	Сургалтын чиглэл, зорилго
Turkish Band NCO Higher Vocational School	United States Armed Forces School of Music	Royal Military School of Music (Kneller Hall)	Бэлтгэж буй сургууль, байгууллага
Хөгжмийн болон цэргийн давхар шалгуур	Хөгжимдөх суурь ур чадварын гүйцэтгэл (сонсох чадварт суурилсан үнэлгээгээр түвшин тогтоон, тохирох шатны сургалт)	Хөгжимдөх суурь ур чадварын гүйцэтгэл, шаталсан сургалт (сонсох чадварт суурилсан үнэлгээгээр түвшин тогтоон, тохирох шатны сургалт)	Сонгон шалгаруулалт
18–25 нас (Цэргийн албанд элсэх насны хүрээнд)	18–28 нас (17 нас өөрийн санал) (Цэргийн албанд элсэх насны хүрээнд)	18–25 нас (16 нас өөрийн санал) (Цэргийн албанд элсэх насны хүрээнд)	Элсэлтийн нас
2–3 жил	Сургалтын эхний шат 6–12 сарын хугацаатай. Үүний дараах ахисан шатанд нэмэлт, гүнзгийрүүлсэн агуулга орно.	1–2 жил	сургалтын тогтолцоо
Цэргийн сахилга, хөгжмийн мэргэжил хосолсон;	Нэгдсэн стандарт, олон улсын түвшний мэргэжил, практик дадлагатай;	Ёслолын уламжлал өндөр хөгжсөн; цэргийн хөгжимчдийн мэргэжлийн ур чадвар;	Сургалтын онцлог

Монгол Улс	ОХУ	Япон
Монгол Улсын тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хэрэгцээнд нийцсэн мэргэжлийн цэргийн үлээвэр хөгжимчдийг бэлтгэх (Төрийн болон Цэргийн ёслол)	Ёслолын хөгжим, найрал хөгжимд зориулсан мэргэжлийн хөгжмийн хүний нөөцийг бэлтгэх	Өөрийгөө хамгаалах хүчний ёслол, албаны болон олон нийтийн арга хэмжээнд оролцох цэргийн хөгжмийн мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх
Монголын Цэргийн Хөгжмийн Политехник Коллеж	Moscow Military Music College / Suvorov Military Schools	Japan Self-Defense Forces (JSDF) Music Training Units
Хөгжмийн авьяас, суурь мэдлэгт тулгуурласан элсэлт	Мэргэжлийн хөгжмийн суурьтай залуусыг сонгон элсүүлнэ	Хөгжимдөх суурь ур чадварын гүйцэтгэл; цэргийн албаны шалгуур давхар хангасан байх
15–18 нас (17 наснаас тооцох) ЦА-ны тухай хууль, 9.2 дах заалт (Суурь боловсрол Эзэмшсэн иргэн) Ахлагчийн албанд элсэх нас (30 хүртэлх нас) ЦА-ны тухай хууль, 10.1 дэх заалт)	15–16 нас (Ерөнхий боловсрол дунд шатнаас) 18–30 нас (Цэргийн албанд элсэх насны хүрээнд)	18–30 нас (Цэргийн албанд элсэх насны хүрээнд)
4.5 жил Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдрийн А/278 дугаар тушаал; (3 жил) Техникийн боловсролын сургалт 1,5 жил буюу 3 улирал суралцаж төгсөнө.	4 жил (2 жилд ерөнхий боловсролын хичээл, сүүлийн 2 жилд хөгжмийн мэргэжил түлхүү орно)	Тогтмол хугацаа байхгүй; Алба хаах явцад шаталсан, тасралтгүй мэргэжил дээшлүүлэх сургалт; (6 түүнээс түүнээс дээш сар)
Цэргийн ёслол, марш, үлээвэр найрал хөгжимд чиглэсэн; практик давамгай;	Ёслолын уламжлал өндөр; орчин үеийн мэргэжлийн сургалт хосолсон;	Ансамбль, дадлагад суурилсан сургалт давамгай;

Дээрх харьцуулсан хүснэгтээс үзэхэд, цэргийн хөгжмийн сургалтын тогтолцоо нь нийгэмд тодорхой дүрэм, үүрэг, зорилготойгоор ажилладаг бөгөөд хөгжимчдийг сонгон шалгаруулж, ур чадвар, цэргийн ёс зүйтэй хослуулан бэлтгэдэг нь тодорхой байна.

Манай Улсын цэргийн хөгжмийн сургалтын тогтолцоо нь төвлөрсөн бүтэцтэй, онол, практик, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрөөр хэрэгжих боловч бусад хөгжингүй орнуудын сургалтын тогтолцооны хувьд хамрах хүрээ, багтаамж, олон салбарт үйлчлэх чадавх нь харьцангуй хязгаарлагдмал хэвээр байна.

ДҮГНЭЛТ

Судалгааны үр дүнгээс харахад, манай улсын цэргийн хөгжмийн сургалт нь зөвхөн хөгжмийн ур чадвар эзэмшүүлэхэд чиглээд зогсохгүй, цэргийн ёс зүй, эх оронч хүмүүжил, уран сайхны мэдлэгийг төлөвшүүлэх чухал үүрэгтэй болох нь нотлогдож байна.

Манай улс цаашид цэргийн хөгжмийн салбарын сургалтын тогтолцоог сайжруулахын тулд гадаадын туршлагаас сургамж авч, хамрах хүрээгээ өргөжүүлэх замаар олон шатны сургалтын тогтолцоог хөгжүүлэх боломж байна.

Цэргийн хөгжмийн салбар нь түүхэн уламжлал, үндэсний онцлог, орчин үеийн хөгжлийн шаардлагад нийцсэн сургалтын тогтолцоог хадгалан хөгжүүлэхийн зэрэгцээ олон улсын стандартыг нэвтрүүлэх шаардлагатайг энэхүү судалгааны үр дүн батлан харуулж байна.

Дэлхийн улс орнуудын цэргийн хөгжмийн сургалтын туршлагаас харахад сургалтын тогтолцоо нь төвлөрсөн удирдлага, шаталсан бүтэц, өндөр шалгуур бүхий сонгон шалгаруулалт, онол-практик хосолсон хөтөлбөр, тасралтгүй мэргэжил дээшлүүлэх тогтолцоонд тулгуурлаж байна.

Үүнээс манай улсад дараах чиглэлүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна. Үүнд:

1. Төвлөрсөн, шаталсан сургалтын тогтолцоо нэвтрүүлэх;

Их Британи, АНУ, ОХУ-ын туршлагаас харахад цэргийн хөгжмийн сургалт нь анхан, дунд, ахисан шатны тодорхой бүтэцтэй байна.

Манай улсад цэргийн үлээвэр хөгжимчний сургалтыг ахисан түвшний үе шаттайгаар хөгжүүлэх шаардлагатай болж байна.

2. Сонгон шалгаруулалтыг олон улсын жишигт ойртуулах;

АНУ болон Их Британид элсэлт нь audition (сонсгол)-д тулгуурлаж, хөгжимдөх ур чадвар, ноот унших чадвар (sight-reading), хөгжмийн онолын мэдлэгийг нарийвчлан үнэлдэг. Манай улсад гүйцэтгэлийн шалгуурыг илүү нарийвчлан тогтоож, үнэлгээний нэгдсэн журмыг боловсруулах боломжтой.

3. Цэргийн болон хөгжмийн давхар бэлтгэлийг сайжруулах;

Турк-ийн туршлагаас харахад ахлагчийн мэргэжлийн болон хөгжмийн сургалтыг хослуулсан тогтолцоо үр дүнтэй байна. Манай улсад цэргийн удирдлага, сахилга, манлайллын сургалтыг хөгжмийн хөтөлбөртэй илүү уялдуулах нь зүйтэй.

4. Ерөнхий боловсролын төвшнөөс хүний нөөцийн суурь бэлтгэх;

Япон Улсын туршлагаас харахад ерөнхий боловсролын сургуулийн үлээвэр найрал хөгжмийн тогтолцоо нь цэргийн хөгжмийн салбарын хүний нөөцийн

суурийг бүрдүүлж байна. Манай улсад ЕБС-ийн үлээвэр найрал хөгжмийн дугуйлан, хамтлагийг бодлогын түвшинд дэмжих нь ирээдүйн цэргийн хөгжимчдийн нөөцийг нэмэгдүүлэх ач холбогдолтой. Жишээлбэл, Тэмүүжин өрлөг, ЕБС-д жишиг 1 анги байгуулж туршилтаар сургалт явуулах.

5. Олон улсын хамтын ажиллагаа, солилцоог өргөжүүлэх;

Их Британи, Турк, АНУ, ОХУ зэрэг орнууд гадаадын суралцагч хүлээн авдаг, хамтарсан сургалт зохион байгуулдаг туршлагатай. Монгол Улс гадаадын цэргийн хөгжмийн сургалтын байгууллагуудтай хамтарсан богино хугацааны сургалт, багш солилцоо, мастер класс, хамтарсан тоглолтыг тогтмолжуулах шаардлагатай. Мөн мэргэжлийн англи хэлний кр цагийг 2 цагаар нэмэгдүүлэх бодлого баримтлах.

6. Гэрээт алба, тогтвортой ажиллах эрх зүйн зохицуулалтыг сайжруулах;

ОХУ-ын туршлагаас үзэхэд төгсөгчид тодорхой хугацааны гэрээгээр алба хаадаг нь тогтвортой байдлыг хангаж байна. Иймд Монгол Улсад цэргийн хөгжмийн мэргэжилтнийг урт хугацаанд тогтвортой ажиллуулах, мэргэжлийн ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, байгууллагын хүний нөөцийн залгамж чанарыг хадгалах зорилгоор эрх зүйн орчныг боловсронгуй болгож, гэрээт албаны тогтолцоог оновчтой хэрэгжүүлэх нь зүйтэй хэмээн дүгнэж байна.

Эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээл:

1. 2026. *Royal Corps of Army Music. British Army Official*. Нэвтэрсэн 2026 оны 3 15.
2. 2026. *the-royal-corps-of-army-music*. Нэвтэрсэн 2026 оны 3 15.
3. 2026. *The Royal Corps of Army Music*. . Нэвтэрсэн 2026 оны 3 15.
4. 2025. *Bando Astsubay Meslek Yüksekokulu Milli Savunma Üniversitesi*. Нэвтэрсэн 2026 оны 3 15.
5. 2026. *Bando Astsubay Meslek Yüksekokulu. Milli Savunma Üniversitesi*. Нэвтэрсэн 2026 оны 3 15.
6. 2025. *U.S. Army Band Career*. Нэвтэрсэн 2026 оны 3 15.
7. Г.Ганбат, Ч.Гансүх Тал 26. 2019. *Цэргийн хөгжмийнхөн*. Улаанбаатар.
8. Хамтын бүтээл. 2021. *Цэргийн хөгжмийн коллежийн түүхэн замнал*. Улаанбаатар.
9. Ц.Оюунчимэг. 2023. “Монгол Улсын зэвсэгт хүчний ахлагч бэлтгэх сургалт, түүнийг боловсронгуй болгох арга зам.”